



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 17/2022

Мандалговь

“Мөнх ногоон тал” ХХК-тай  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж-Луус сум” ажлыг 49,950,000 (дөчин есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Мөнх ногоон тал” ХХК-тай 49,950,000 (дөчин есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мөнх ногоон тал” ХХК-ийн захирал (Д.Давааням)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150647